



АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

Шударга ёс, хөгжил дэвшилд

ШУДАРГА ЁС, ХӨГЖИЛ ДЭВШИЛД:

ХУВИЙН ХЭВШЛИЙН ОРОЛЦОО

УИХ.ОН
СУДАЛГААН

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

Шударга ёс, хөгжил дэвшилд

UIH.MN
СЭЛЭН ААНДСАН



АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

Шударга ёс, хөгжил дэвшилд



The Asia Foundation

Improving Lives, Expanding Opportunities

Canada

Хянан тохиолдуулсан:

Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн дарга, эрхэлсэн комиссар

Д.Дуламсүрэн

Боловсруулсан:

Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн ажилтан, комиссар

С.Галбадрах

Энэхүү гарын авлагыг Канадын Гадаад хэргийн яамны дэмжлэгтэйгээр Азийн сан хэрэгжүүлж буй “Ардчилсан оролцоотойгоор төрийн албанд сайн засаглал, ил тод байдлыг бэхжүүлэх нь” (STEPS) төслийн дэмжлэгтэйгээр хэвлэв.

Цаасны хэмжээ: 213x216

Хэвлэсэн тоо: 3000

“УРАНГАР ПРЕСС” ХХК-д хэвлэв.

УИН.МН
СУДАЛГААНЫ САН



АГУУЛГА

Оршил	4
Ёс зүй гэж юу вэ?	6
Бизнесийн ёс зүй	8
Ёс зүйн кэйс	9
Сэвтсэн нэр хүндээ сэргээхийн тулд хэрхэн өөрчлөлтийг манлайлах вэ?	11
Бизнесийн ёс зүй ба авлигын холбоо хамаарал	12
Авлига, түүний хэлбэрүүд	13
Авлигын эсрэг хууль тогтоомж	15
Бизнесийн орчин дахь авлигын судалгаа	17
Улс орны бизнесийн шударга байдлын судалгаа-BICA	18
Бизнес үзүүлэх авлигын хор уршиг	21
Компаниа авлигагүй байлгах, авлигаас урьдчилан сэргийлэх 6 арга зам	23
Олон улсын туршлага	25
Монгол Улсын хувийн хэвшил дэх авлигын нөхцөл байдал	28
Шударга ёс, хөгжил дэвшилд: Хувийн хэвшлийн оролцоо	32
Хавсралт	34

ОРШИЛ

Аливаа бизнес авлигаас ангид байх, нийгмийн баримжаатай үйл ажиллагаа явуулахад Компанийн нийгмийн хариуцлагыг сайн дурын үндсэн дээр хэрэгжүүлэх нь чухал бөгөөд энэхүү цогц үйл ажиллагааны нэг бүрдэл хэсэг нь шударга үйл ажиллагаа, ил тод байдлыг хангах болон аливаа авлига, хээл хахуулиас ангид байх явдал юм.

Зах зээлийн, өрсөлдөөнт эдийн засаг бүхий орнуудын аж ахуйн нэгж, компаниуд өдөр тутмын үйл ажиллагаандаа ёс зүйг эрхэмлэн сахиснаар бизнесийн нэр хүндээ өсгөх, зах зээлд эзлэх байр сууриа хадгалахад чухал ач холбогдолтой. Эрдэмтэн судлаачид, хувийн




хэвшлийн нэр хүнд бүхий төлөөлөгчид, улс төрийн зүтгэлтнүүд “бизнесийн ёс зүй”, “нийгмийн хариуцлага”, “шударга өрсөлдөөн” гэх мэт ойлголтуудыг баяжуулж судлан, олон нийтэд таниулсаар ирсэн.

“Бизнесийн ёс зүй” нь өргөн хүрээний ойлголт, түүнд авлигын асуудал чухал байр суурь эзэлдэг. Учир нь авлигаас ангид байх нь тухайн компанийн ирээдүйн хөгжил дэвшилд чухал нөлөө үзүүлээд зогсохгүй улсын нийгэм, эдийн засагт ч үнэтэй хувь нэмэр оруулдагтай холбоотой юм.

Шинээр хуулийн этгээд байгуулан ажиллуулж байгаа иргэн, өдөр тутамдаа бизнесийн холбогдолтой аливаа асуудлыг шийдвэрлэж байдаг энгийн бизнес эрхлэгч, том корпорацийн менежер хэн боловч энэ асуудлын ач холбогдлыг нь өндрөөр үнэлэн, бизнесийн ёс зүйтэй холбоотой шийдвэрээ зөв гаргаж байгаа гэдэгт эргэлзэхгүй байна.

Энэхүү гарын авлага нь бизнес эрхлэгч Таны ёс зүйн талаарх мэдлэгт хувь нэмэр оруулж, цаашид шийдвэрээ зөв гаргахад тань туслана гэдэгт итгэж байна.



ЁС ЗҮЙ ГЭЖ ЮУ ВЭ?

Ёс зүй буюу ёс суртахууны философи нь зан үйл, үйлдлийн зөв, буруугийн талаарх ойлголтыг нэгтгэн тодорхойлж, бусдад биеэ хэрхэн зөв авч явахыг санал болгоход чиглэсэн философийн салбар юм. Ёс зүй нь сайн ба муу, зөв ба буруу, буян ба нүгэл, гэмт хэрэг ба шударга ёс гэх мэт ойлголтуудыг тодорхойлох замаар хүмүүст тулгарч буй ёс суртахууны асуудлыг шийдвэрлэхийг эрэлхийлдэг.

Өнөө үед ёс зүйг дараах гурван салбарт ангилан хувааж, судлан үзэж байна.

Мета-ёс зүй

Норматив ёс зүй

Хэрэглээний ёс зүй

Мета-ёс зүй

Мета-ёс зүй нь юуг зөв, юуг буруу болохыг онолын түвшинд судалдаг ёс зүйн философийн салбар юм. Тухайлбал, “албан үүргээ гүйцэтгэсний төлөө би бэлэг авах нь зөв үү?” гэсэн асуулт нь мета-ёс зүйд бус, харин хэрэглээний ёс зүйд хамаарна. Тэгвэл мета-ёс зүйн асуудлууд нь хийсвэр, онолын шинжтэй бөгөөд “бид юуг зөв, эсхүл буруу болох талаар нэгдсэн ойлголттой болж чадах эсэх нь үүнд хамаардаг.

Норматив ёс зүй

Норматив ёс зүй нь хэн нэгэн тодорхой нөхцөл байдалд ямар үйлдэл хийвэл зохистой болохыг тайлбарладаг ёс зүйн философийн салбар юм.

Норматив ёс зүй нь ямар нэгэн үйлдлийг сайн, муу болгож байгаа зүйлийг судалдагараа мета-

ёс зүйгээс ялгаатай. Гэвч ёс зүйн асуудлууд нь зөвхөн сайн, муу гэж тайлбарлагдахгүй байх тохиолдол их гардаг тул ХХ зууны дунд үеэс энэхүү салбарын судалгааны ач холбогдол нь буурсан.


Хэрэглээний ёс зүй

Хэрэглээний ёс зүй нь амьдралд тохиолддог аливаа нөхцөл байдалд ёс зүйн онолыг хэрэглэхэд чиглэсэн ёс зүйн философийн салбар юм. Энэхүү салбар нь инженерийн ёс зүй, биотехнологийн ёс зүй, бизнесийн ёс зүй, төрийн албаны ёс зүй, эмчийн ёс зүй, сувилагчийн ёс зүй гэх мэт чиглэлүүдэд хуваагддаг.

Хэрэглээний ёс зүй нь бодлогын шинжтэй асуудлаас гадна хувь хүнд тулгарсан ёс зүйн асуултад тодорхой хариу өгч байдаг. Тухайлбал, “Хүний эрх гэж юу вэ? Түүнийг хэрхэн тодорхойлох вэ?”, “Амьтанд эрх гэж байдаг уу?”, “Үр хөндөлт хийлгэх нь ёс зүйтэй үйлдэл мөн үү?”, “Эмчилгээ хийснийхээ төлөө бэлэг авч болох уу?” гэх мэт асуултуудад хариулт өгөхийг зорьдог.

Хүний сэтгэхүй нь аливаа зүйлийг сайн, муу гэж эсрэг тэсрэгийн туйлаар авч үзэх сэтгэлгээнд илүү дассан байдаг. Гэвч ёс зүйн асуудал нь олон талт, төрөл бүрийн “өнгө”-нөөс бүрддэг. Иймд ёс зүйн аливаа асуудалд “сайн ба муу”, “зөв ба буруу” гэх тодорхойлолт таардаггүй. Тухайн нөхцөл байдлыг дээрдүүлэхийн тулд олон төрлийн шийдвэр гаргаж болох бөгөөд тэдгээр шийдвэрүүд нь аль нэг талд тус дэм болох эсэх нь эргэлзээтэй байдаг.

ХЭРЭГЛЭЭНИЙ ЁС ЗҮЙН ЗАРИМ САЛБАРУУД



Эх сурвалж: <https://en.wikipedia.org/wiki/Ethics>

БИЗНЕСИЙН ЁС ЗҮЙ

“Бизнесийн ёс зүй” гэж бизнесийн орчинд үүсч болох ёс зүй, ёс суртахууны асуудлууд болон ёс зүйн зарчмыг судалдаг хэрэглээний буюу мэргэжлийн ёс зүйн нэгэн төрөл юм. Энэ нь хувь хүн, бизнесийн байгууллагын аль алинд нь хамааралтай. Бизнесийн ёс зүй нь хувь хүн, байгууллагаас гаргасан мэдэгдэлд болон хууль тогтоомжоос гадна тусгагдсан байдаг. Эдгээр хэм хэмжээ, үнэлэмж, үйл ажиллагаа нь хувийн хэвшлийн байгууллагыг удирдах зарчим болж тогтдог. Бизнесийн үйл ажиллагаандаа ёс зүйг сахин мөрдсөнөөр харилцагч, хэрэглэгч, хувьцаа эзэмшигчидтэйгээ найрсаг дотно харилцааг үүсгэн хөгжүүлэхэд дэмжлэг болдог. Бизнесийн ёс зүйд байгууллагын стандарт, зарчим, үнэт зүйлс, тухайн бизнесийн байгууллагад ажиллаж байгаа хувь хүмүүсийн үйлдэл, биеэ авч явах байдлыг тусгасан хэм хэмжээ байдаг.

1980, 1990-ээд оноос эхлэн бизнес эрхлэгч, эрдэмтэн судлаачид бизнесийн ёс зүйг судалж

үйл ажиллагаандаа мөрдөж эхэлсэн гэж үзэж болно. Үндэстэн дамнасан, том хэмжээний корпорациуд үүсэн бий болсноор ёс зүйн дүрэм, журмын хөгжлийг хурдасгаж байна. Ихэнх хувийн хэвшлийн байгууллагууд, үндэстэн дамнасан корпорациуд “ёс зүйн дүрэм”, “нийгмийн хариуцлагын дүрэм” зэргийг гарган ашгийн бус үнэт зүйлийн төлөөх өөрсдийн амлалтаа өгч, баталгаажуулж байна.

Нэрт эдийн засагч Адам Смит “Ижил төрлийн үйл ажиллагаа явуулдаг хүмүүс заримдаа хүсэл сонирхлын үүднээс уулзаж ярилцдаг. Гэвч ийм ярилцлага нь эцсийн эцэст нийтийн ашиг сонирхлын эсрэг, эсхүл зарим тохиолдолд үнэ өсгөх хуйвалдаан болж өндөрлөдөг”¹ гэж өгүүлсэн байдаг. Төрөөс бизнесийн байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг хууль тогтоомжийн хүрээнд зохицуулдаг бол харин ёс зүй нь төрийн зохицуулалтын гадна оршдог үйл ажиллагаа, нөхцөл байдлыг зохицуулдаг.



Эх сурвалж: https://en.wikipedia.org/wiki/Business_ethics

1 Smith, A (1776/ 1952) An Inquiry Into the Nature and Causes of the Wealth of Nations. Chicago, Illinois: University of Chicago Press, p. 55

ЁС ЗҮЙН КЭЙС

ӨМНӨД ТЭНГИСИЙН КОМПАНИ²



Олон жил үргэлжилсэн дайны дараа 1713 онд Нэгдсэн Вант Улс нь Испани Улстай “Үтрехтийн гэрээ”-г байгуулж, Өмнөд Америк тив орчмын далайн эрэг орчим худалдаа хийх боломжийг нээсэн байна. Гэвч энэхүү гэрээг Испани Улс төд удалгүй цуцалжээ. Энэ тухай мэдээллийг Нэгдсэн Вант Улсын хөрөнгийн биржийн арилжааны үеэр нууцалсны улмаас 1720 он гэхэд “Өмнөд тэнгисийн компани”-ийн хувьцааны үнэ 1000 фунтэд хүрч, үнэлгээ нь хэт өссөн. Мөн оны 9 дүгээр сард бодит байдал ил болж, хувьцааны үнэ огцом унасан байна. Энэ хэргийг тус улсын парламент мөрдөн шалгаж, хэд хэдэн улс төрч, Засгийн газрын гишүүдийн буруутай үйлдлийг тогтоож, хорих ялаар шийтгэсэн ажээ.

ЭНРОН³



Endless possibilities.™

Шинэ зууны эхэнд АНУ-ын Хьюстонд төвтэй эрчим хүчний Энрон компани нь хөрөнгө, орлого, өсөлт дэвшлээрээ бусдыг гайхшруулж байв. Тус компанийн нягтлан бодох бүртгэлийг хариуцан хэрэгжүүлдэг компани болох “Артур Андерсон”-ы нарийн чанд бодож боловсруулсан дансны луйвар илэрсний улмаас дампуурлаа зарласан. 2001 оны 10 дугаар сард тус компани олон нийтэд орлогын тайлангаа бодитоор танилцуулахад нэгж хувьцааных нь үнэ 90 ам.доллараас 50 цент хүртэл унаж, олон зуун хөрөнгө оруулагчдын хөрөнгө нүд ирмэхийн зуур салхинд хийссэн байна.

ДОЙЧЭ БАНК ХК⁴



Олон улсад банк, санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч, Герман Улсаас гаралтай тус банк нь Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд болон зарим хөрөнгө оруулагчдынхаа хувийн амьдралыг 2006 оноос эхлэн тагнаж байсан нь ил болсон. Америк, Европ, Ази, Номхон далайн бүс нутгийн олон оронд үйл ажиллагаагаа явуулдаг тус компанийн энэ зохисгүй үйлдэл нь том дуулиан дэгдээжээ. Үүнээс хойш Герман Улсын Засгийн газар компани, аж ахуйн нэгжийн ажилтнуудад зориулсан хувийн нууцыг хамгаалах тухай шинэ журам мөрдүүлэхээр болсон.

Эх сурвалж: https://en.wikipedia.org/wiki/List_of_corporate_collapses_and_scandals
<https://list25.com/25-biggest-corporate-scandals-ever/5/>

2 https://upload.wikimedia.org/wikipedia/commons/8/8e/SouthSeaCompany_Armorials.png

3 <https://cdn.worldvectorlogo.com/logos/enron.svg>

4 https://staticseekingalpha3.a.ssl.fastly.net/images/marketing_images/fair_use_logos_products/sacl_db_deutsche_bank_ag_logojpeg

ХЕВЛЭТ ПАКАРД⁵



Тус компанийн ерөнхий захирал Патришиа Данн хараат бус мөрдөгчийг хөлслөн өөрийн компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд болон зарим нэгэн сэтгүүлчдийг мөрдүүлж, тэдний утасны бичлэгийг авчээ. Патришиа Данн энэ үйлдэл нь ил болсны дараа 2006 онд албан тушаалаасаа буусан байна.

ВОЛКСВАГЕН⁶



2005 онд Волксваген автомашин үйлдвэрлэгчийн удирдах түвшний менежерүүд бизнесийн гэрээ, хэлцэл хийхийн тулд хээл хахууль өгдөг байсан нь ил болсон. Тус компанийн удирдлагууд энэ хэргийг компанийхаа ашиг сонирхлын төлөө хийж байсан гэж хаацайлсан боловч энэ тайлбар нь тус болоогүй юм. Энэхүү хэрэг 2005 онд олон нийтэд ил болсон боловч холбогдох мөрдөн шалгах ажиллагаа, буруутай этгээдүүдэд хариуцлага тооцох асуудал 5 жил тасралтгүй үргэлжилсэн аж.

ФЕЙСБҮҮК⁷



2018 оны эхээр тус нийтийн сүлжээний 87 сая гаруй хэрэглэгчдийн мэдээлэл “Кембридж Аналитика” хэмээх улс төрийн зөвлөгөө үзүүлдэг фирмд алдагдсан. Гэвч Фейсбүүк компани “Кембридж Аналитика” фирм хэрэглэгчдийнх нь мэдээллийг тусгай програм ашиглан цуглуулж байсныг мэдсэн боловч тодорхой арга хэмжээ аваагүй талаараа мэдэгдсэн нь энэхүү хэрэг явдлын хамгийн сэтгэл түгшүүлсэн асуудал болж байв. Хувь хүний нууцад халдсан энэ үйл явдлаас болж тус компанийн үүсгэн байгуулагч Марк Зукерберг АНУ болон Европын холбооны эрх бүхий байгууллагаас зохион байгуулсан олон тооны сонсох ажиллагаанд дуудагдсан. Энэхүү хэрэг явдлаас болж тус компанид итгэх хэрэглэгчдийн итгэл суларсан аж.

5 https://sarkarirecruitment.com/wp-content/uploads/2016/12/hp_log0.png

6 https://upload.wikimedia.org/wikipedia/commons/thumb/6/6d/Volkswagen_logo_2019.svg/600px-Volkswagen_logo_2019.svg.png

7 https://www.facebook.com/images/fb_icon_325x325.png

СЭВТСЭН НЭР ХҮНДЭЭ СЭРГЭЭХИЙН ТУЛД ХЭРХЭН ӨӨРЧЛӨЛТИЙГ МАНЛАЙЛАХ ВЭ?



Веллс Фарго нь АНУ-ын Сан Франциско хотод төвтэй, санхүүгийн үйлчилгээ үзүүлдэг компани юм. Тус компанийн ажилтнууд нь олон нийтийн сүлжээнд нэр нь үл мэдэгдэх олон сая хэрэглэгчийн

хуурамч бүртгэл нээсэн нь ил болсноор тус компанийн нэр хүнд унасан. Энэ хэрэг явдлын дараа тус компани шинэ гүйцэтгэх захирлаараа Чарльз В.Шарфийг томилжээ. Түүний гол зорилго нь компанийхаа сэвтсэн нэр хүндийг дахин сэргээх явдал байв. Энэ нь нэр хүндээ сэргээхийг хүсч байгаа компаниудын хувьд нийтлэг тохиолддог асуудал юм. Тэгвэл бизнесийн нэр хүндээ сэргээх алхмын талаар Форбс сэтгүүлийн нийтлэлч Цасон Вингардын санааг дор танилцуулья.

1. Хүлээн зөвшөөрч, уучлал гуй.

Ихэнх компаниуд болсон явдлыг нууж хаахыг урьтал болгодог. Гэвч болсон явдлын талаар олон нийтэд цаг алдалгүй байр сууриа мэдэгдэж, тэр даруй уучлал гуйх нь бизнесийн нэр хүндийг хадгалж үлдэх хамгийн зөв алхам байдаг гэдгийг судлаачид санал нэгтгэйгээр батлан хэлж байна. Албан ёсоор уучлал гуйсны дараа

Веллс Фаргогийн нэр хүнд сэргэж эхэлсэн гэж үздэг.

2. Байгууллагынхаа соёлыг өөрчил. Зөрчилтэй үйл ажиллагааны дараа буруутныг ажлаас чөлөөлж арга хэмжээ тооцох нь хангалтгүй бөгөөд уг нөхцөл байдал үүсэх болсон шалтгааныг засч, байгууллагынхаа соёлыг зөв гольдролд оруулах нь түүнээс чухал байдаг ажээ.
3. Брендээ дахин тодорхойл. Бизнесийн ёс зүйн зөрчил, гэмт хэргээс улбаалан компанийн үйл ажиллагаа саардаг боловч энэ үе нь бараа, үйлчилгээнийхээ брендэд анхаарах боломжийг олгодог байна. Чухам дуулиан шуугианы дунд байх энэ үеэд тус компаниас хийх дараагийн алхмыг олон нийт анхааран ажиглаж байдаг. Иймд олон нийтийн анхаарлыг зөвөөр ашиглаж, компанийхаа үнэт зүйл, инноваци, манлайлалд анхаарах нь бизнесийн нэр хүндийг сэргээх боломжид тооцогддог ажээ.

Эх сурвалж: <https://www.forbes.com/sites/jasonwingard/2019/11/01/wells-fargos-mea-culpa-how-to-lead-change-after-a-scandal/#7246f5cb5b74>

БИЗНЕСИЙН ЁС ЗҮЙ БА АВЛИГЫН ХОЛБОО ХАМААРАЛ

Ёс зүйн асуудлаа дараах бүрэлдэхүүн хэсэгт хувааж болох юм. Үүнд:

- Үнэнч байх
- Шударга байх
- Ил тод байх
- Хариуцлагатай байх
- Нууцыг чандлан хадгалах
- Стандартыг мөрддөг байх
- Бусдыг хүндлэх
- Хуульд захирагдах

Тэгвэл 2017 онд хийсэн судалгаа⁸-ны дүнгээр дараах хүчин зүйлс авлига гарах шалтгаан нөхцөл болж байдаг аж. Үүнд:

- Хөрөнгө мөнгөний шунал
- Зах зээл, улс төрийн монопольчлол
- Ардчилал сул хөгжих, иргэний нийгмийн оролцоо хангалтгүй байх, улс төрийн ил тод байдал муу байх
- Хүнд суртал, төрийн захиргааны нүсэр бүтэц
- Хэвлэлийн эрх чөлөө хангалтгүй байх
- Эдийн засгийн эрх чөлөө муу байх

- Ястан, үндэстний хоорондын ялгаа их байх
- Жендерийн тэгш бус байдал
- Ядуурал
- Улс төрийн тогтворгүй байдал
- Өмчлөх эрх хангалтгүй зохицуулагдсан байх
- Бусад орноос авлигын буруу үлгэр дуурайл авах
- Боловсролын түвшин доогуур байх
- Нийгмийн оролцоо хангалтгүй байх
- Хэт үрэлгэн байдал.

Авлига гарах шалтгаан нөхцлүүдэд “иргэний нийгэм” болон “нийгмийн оролцоо” гэж хоёр удаа давтан орсон нь санаандгүй тохилдол биш. Энэхүү нийгмийн эс ширхэг болж байгаа бизнес эрхлэгч Та өөрийн удирдаж байгаа аж ахуйн нэгж, компанидаа ёс зүйн соёлыг бий болгосноор авлигатай тэмцэхэд үнэтэй хувь нэмэр оруулах нь эргэлзээгүй юм. Тэгвэл авлигаас урьдчилан сэргийлэхийн тулд авлига гэж юу болох, түүнтэй хэрхэн тэмцэх талаарх мэдээлэлтэй энэхүү гарын авлагаас уншиж танилцарай.

УИТ.МН
СУДАЛГААНЫ САН

Эх сурвалж: <https://en.wikipedia.org/wiki/Corruption>
https://en.m.wikipedia.org/wiki/Professional_ethics

8 Dimant, Eugen; Tosato, Guglielmo (1 January 2017). “Causes and Effects of Corruption: What Has Past Decade’s Empirical Research Taught Us? a Survey”. *Journal of Economic Surveys*. 32 (2): 335–356. doi:10.1111/joes.12198. ISSN 1467-6419.

АВЛИГА, ТҮҮНИЙ ХЭЛБЭРҮҮД

Авлигыг шууд тодорхойлоход бэрхшээлтэй. Учир нь авлига олон хэлбэрээр илэрч, түүнийг үйлдэж байгаа гэмт этгээдүүд ул мөрөө баллахын тулд төрөл бүрийн арга замыг сүвэгчилдэг. Транспэрэнси Интернэшнл байгууллагаас “хувийн ашиг хонжооны төлөө эрх мэдлээ урвуулан ашиглах” гэсэн тодорхойлолтыг гаргасан байдаг. Энэхүү тодорхойлолт дараах гурван хэсгээс бүрдэж байна:

1

Нийтийн алба болон хувийн хэвшил

Авлига нь нийтийн алба болон хувийн хэвшлийн аль алинд нь гарч байдаг. Түүнчлэн үүнд хэвлэл мэдээллийн хэрэгсэл, иргэний нийгмийн байгууллага зэрэг оролцогч талуудыг хамруулж болно. Оролцогч тал гэдэгт хувь хүн, компани, байгууллага, улс төрийн нам гэх мэт субъектүүдийг ойлгож болно.

2

Эрх мэдлээ урвуулан ашиглах

Авлига нь төрийн болон хувийн хэвшилд эрхэлж байгаа албан үүрэгтэй холбоотойгоор эрх мэдлээ урвуулан ашиглах үйлдлээр илэрдэг.

3

Ашиг хонжоо


Авлигын хэрэгт оролцсон талууд хөрөнгө мөнгө, эсхүл хууль бус давуу байдал олж авах замаар ашиг хонжоо олдог.

UIH.MN
СҮДАЛГААНЫ САН

Түүнчлэн авлигыг “дээд түвшний”, “доод түвшний” гэж нэрлэх тохиолдол байдаг.

ДЭЭД (ӨНДӨР) ТҮВШНИЙ АВЛИГА

Энэ нь аль ч байгууллагын хамгийн дээд түвшний хүрээнд үйлдэгддэг. Өөрөөр хэлбэл, энэ төрлийн авлигын гэмт хэргийг бодлого, дүрэм, журам, шийдвэр гаргадаг этгээдүүд үйлддэг. Түүнчлэн өндөр түвшний авлигатай их хэмжээний хөрөнгө мөнгөний асуудал холбогддог. Энэ төрлийн авлигыг “улс төрийн авлига” гэж нэрлэх тохиолдол бий.



ДООД ТҮВШНИЙ АВЛИГА

Төрийн байгууллага болон иргэдийн хооронд өдөр тутам гарч болох жижиг хэмжээний авлигыг хэлнэ. Хэдийгээр их хэмжээний хөрөнгө мөнгөтэй төдийлөн холбогддоггүй ч дээд түвшний авлигатай дүйцэхүйц хэмжээний хохирол учруулдаг.



Дэлгэрэнгүй мэдээллийг дараах холбоосоос үзнэ үү: <https://www.u4.no/topics/anti-corruption-basics/basics>

АВЛИГЫН ЭСРЭГ ХУУЛЬ ТОГТООМЖ

Авлигын эсрэг хууль тогтоомж

Үүнд:

- Үндсэн хууль
- Авлигын эсрэг НҮБ-ын конвенци
- Авлигын эсрэг хууль
- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль
- Эрүүгийн хууль
- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль
- Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль
- УИХ-ын ХЗБХ-ны 2012 оны 5 дугаар тогтоол гэх мэт.

Авлигын эсрэг хууль нь 2006 онд батлагдсан. Энэ хуулиар авлигатай тэмцэх үйл ажиллагаа, авлигатай тэмцэх байгууллагын эрх зүйн үндсийг тодорхойлж, тэдгээртэй холбогдон гарах харилцааг зохицуулж, “авлига”, “ашиг хонжоо”, “албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашиглах”, “давуу байдал” зэрэг нэр томьёог тайлбарласнаас гадна авлигаас урьдчилан сэргийлэх ажиллагаа, соён гэгээрүүлэх ажиллагаа, төрийн албан тушаалтанд хориглох зүйлийг тусгасан.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль нь 2012 онд батлагдсан бөгөөд уг хуулиар нийтийн албан тушаалтны хувийн ашиг сонирхол болон хуулиар хүлээсэн албан үүрэг хоорондын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах, хянах замаар нийтийн албаны үйл ажиллагааг нийтийн ашиг сонирхолд нийцүүлэх нөхцөлийг баталгаажуулж, төрийн албаны ил тод, итгэл даах байдлыг хангахыг зорьсон. Энэхүү хуулиар албан тушаалтанд тавигдах хориглолт, хязгаарлалтыг дэлгэрэнгүй зохицуулсан. Үүнд:

- ✓ Албаны мэдээллийг ашиглахтай холбогдсон хориглолт
- ✓ Оффшор бүсэд банкны данс эзэмших, хөдлөх, үл хөдлөх хөрөнгө өмчлөх, хуулийн этгээд байгуулахтай холбогдсон хориглолт
- ✓ Албан үүргээ гүйцэтгэхтэй холбогдсон хориглолт, хязгаарлалт
- ✓ Шийдвэр гаргахад нөлөөлөхийг хориглох
- ✓ Сурталчилгаатай холбогдсон хязгаарлалт
- ✓ Төлөөлөлтэй холбогдсон хязгаарлалт
- ✓ Төлбөр авахтай холбогдсон хязгаарлалт
- ✓ Бэлэг авахтай холбогдсон хязгаарлалт
- ✓ Хандив авахтай холбогдсон хязгаарлалт
- ✓ Давхар ажил эрхлэхтэй холбогдсон хязгаарлалт

- ✓ Аж ахуйн үйл ажиллагаа эрхлэхтэй холбогдсон хориглолт
- ✓ Албан тушаалаас чөлөөлөгдсөний дараах хязгаарлалт
- ✓ Бусад орлогын хязгаарлалтыг авч үзсэн байна.

Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгыг 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөж байгаа бөгөөд тус хуулийн 22 дугаар бүлэгт авлигын гэмт хэргийг хуульчилсан. Үүнд:

- Эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах
- Гадаад улсын төрийн байгууллага, олон улсын байгууллагын албан тушаалтан эрх мэдлээ урвуулан ашиглах
- Хахууль авах
- Хахууль өгөх
- Гадаад улсын төрийн байгууллага, олон улсын байгууллагын албан тушаалтныг хахуульдах
- Улсын нөөцийг хууль бусаар зарцуулах, үрэгдүүлэх
- Төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах
- Төрийн өмчийн төсвийн бус хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах
- Үндэслэлгүйгээр хөрөнгөжих
- Дураараа аашлах
- Хуулийн этгээдийн эрх мэдлийг урвуулан ашиглах зэрэг гэмт хэрэг хамаарна.

Авлигын эсрэг НҮБ-ын конвенци нь авлигатай тэмцэх ажиллагаа, түүнээс урьдчилан сэргийлэх арга техник, олон улсын хамтын ажиллагаа, хууль эрх зүйн орчныг шинэчлэх зэрэг олон чухал асуудлыг олон улсын хэмжээнд нэгтгэн зохицуулсан баримт бичиг юм. Монгол Улс нь тус конвенцид 2007 онд нэгдэн орсноор авлигатай тэмцэх үйл хэргийг тууштай хэрэгжүүлэх үүргийг олон улсын өмнө хүлээсэн юм. Энэхүү конвенцид хувийн

хэвшлийн хүрээн дэх авлигын талаар тодорхой асуудлуудыг тусгаж, тухайн улс оронд холбогдох үүргийг хариуцуулсан байдаг.

Конвенцийн 12 дугаар зүйлд:

“Авлигаас урьдчилан сэргийлэх үүднээс оролцогч улс бүр энэхүү конвенцийн дагуу тогтоосон аливаа гэмт хэргийг үйлдэх зорилгоор явуулсан дараахь үйлдлийг хориглоход нягтлан бодох бүртгэл тооцоо хөтлөх, санхүүгийн тайланг ил тод болгох, нягтлан бодох бүртгэлийн болон аудитын стандартын талаарх дотоодын хууль тогтоомжийнхоо дагуу шаардлагатай байж болох арга хэмжээг авна:

- (a) бүртгэлээс гадуур данс нээх;
- (b) бүртгэлээс гадуур буюу буруу тодорхойлсон гүйлгээ хийх;
- (c) гараагүй зардлыг бүртгэх;
- (d) объектыг нь буруу тодорхойлсон өглөг үүсгэх;
- (e) хуурамч баримт бичиг ашиглах;
- (f) нягтлан бодох бүртгэлийн баримт бичгийг хуульд заасан хугацаанаас өмнө санаатайгаар устгах.” гэж заажээ.


Түүнчлэн мөн хэсэгт “Оролцогч улс бүр энэхүү конвенцийн 15, 16 дугаар зүйлийн дагуу тогтоосон гэмт хэргийн бүрэлдэхүүн хэсэг болох хээл хахуульд өгсөн зардал болон зохих тохиолдолд авлигын үйлдлийг дэмжсэн бусад зардлыг татвар ногдох зардлаас хасч тооцохыг үл зөвшөөрнө” гэж тусгажээ.

БИЗНЕСИЙН ОРЧИН ДАХЬ АВЛИГЫН СУДАЛГАА

Авлига нь биет зүйл биш боловч нийгэм, эдийн засагт байнгын хар ул мөр үлдээдэг. Авлигын улмаас учирсан хохирол ихэнх тохиолдолд нийгэмд үйлдэгддэг бусад гэмт хэргийн улмаас учирсан хохиролтой харьцуулахад цар хүрээгээр илүү байдаг. Тэгвэл бизнесийн орчинд авлига гарах болсон учир шалтгааныг тогтоож, гарч болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх, түүнийг таслан зогсоохын тулд бизнесийн орчинд хамаарах авлигыг хэмжих, судлах зайлшгүй шаардлага гардаг. Гэвч авлигыг судлах, түүний илрэх давтамжийг хэмжихэд

учирдаг нэг хүндрэл нь авлига биет зүйл биш, нийгмийн үзэгдэл байдагтай холбоотой юм. Иймд олон улсын хэмжээнд авлигыг судлахдаа санал асуулгад оролцогчдын төсөөллөөр дүгнэлт гаргадаг уламжлал тогтжээ.

Авлигын талаар олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн төсөөллийн ийм судалгааны нэг нь Транспэрэнси Интернэшнл байгууллагын **“Авлигын төсөөллийн индекс”** юм. Авлигын төсөөллийн индекс 2019 оны байдлаар улс орнуудын хэмжээнд дараах дүнтэй гарсан байна.



Эх сурвалж: <https://www.transparency.org/cpi2018>

УЛС ОРНЫ БИЗНЕСИЙН ШУДАРГА БАЙДЛЫН СУДАЛГАА - ВІСА

ШУДАРГА БИЗНЕС МОНГОЛ УЛСЫН ХӨТӨЛБӨР 2018

“Трансперэнси Интернэшнл Монгол” ТББ-аас эрхлэн гаргадаг “Шударга бизнес Монгол Улсын хөтөлбөр” нь төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн шударга байдал, тэдгээртэй холбогдох эрх зүйн орчинд үнэлгээ хийх зорилготой судалгаа юм. Энэхүү хөтөлбөрөөс хувийн хэвшлийн шударга байдалтай холбогдох үнэлгээг уншигч Танд танилцуулж байна.

ЁС ЗҮЙТ БАЙДЛЫН МЕНЕЖМЕНТ - 25

Олон нийтэд ил тод авлигын эсрэг бодлого, хөтөлбөр маш цөөн. Хөтөлбөрүүд нь бизнесийн онцлог, авлигын эрсдэл зэрэг бүхий л асуудлыг дэлгэрэнгүй, цогцоор нь тусгаагүй байна. Цөөн хэдэн гадаадын хөрөнгө оруулалттай компаниуд өөрсдийн ёс зүйн дүрмийг бэлтгэн нийлүүлэгч, гэрээлэгч нарыг дагаж мөрдөхийг шаарддаг. Компаниудын хөтөлбөрөө хянах, үнэлэх хувь маш доогуур үзүүлэлттэй байна. Шүгэл үлээгчийн талаарх мэдлэг муу, соёл тогтоогүйгээс мэдээлэгчийг хамгаалах механизм бүрдээгүй. Тухайлбал,

Бодлогын баримт бичиг - 25

Компаниуд ямар түвшинд авлигын эсрэг албан ёсны бодлогыг бий болгодог вэ?

Хөтөлбөрийн хэрэгжилт - 25

Компаниуд ямар түвшинд авлигын эсрэг хөтөлбөртэй байна вэ?

Шүгэл үлээх – 25

Компаниуд зөрчлийн талаар мэдээлэх эрсдэлгүй, нууц, аюулгүй сувгуудыг ямар түвшинд хангадаг вэ?

Бизнес түншийн менежмент - 25

Компаниуд холбогдох бизнесийн түншүүддээ авлигын эсрэг хөтөлбөрийнхөө дагуу ямар түвшинд шаардлага тавьдаг вэ?

АУДИТ БОЛОН БАТАЛГААЖУУЛАЛТ - 50

Монгол Улсын хувьд дотоод аудитын нэгжтэй компани ховор. Хуульд заасан босгоос дээш бүх аж ахуйн нэгж, байгууллагууд мэргэжлийн гэрчилгээтэй аудитор, эсхүл аудитын компаниар хөндлөнгийн аудит хийлгэх үүрэгтэй. Дотоод хяналтыг баталгаажуулсан аудит хийгддэггүй. Аудитын тухай хуулиар аудитын үйлчилгээ, аудитын бус үйлчилгээг хамтад нь “аудитын үйл ажиллагаа” хэмээн авч үздэг. Банкнаас бусад байгууллагад хөндлөнгийн аудитаар баталгаажсан санхүүгийн тайлан, аудитын дүгнэлтийг олон нийтэд ил тод, нээлттэй мэдээлэхийг шаарддаггүй. IFRS⁹ стандартын хэрэгжилтийг баталгаажуулах боломжгүй байна. Тухайлбал судалгааны дүнгээр:

Дотоод хяналт ба мониторингийн бүтэц - 50

Компаниуд авлигыг хянах, урьдчилан сэргийлэх дотоод хяналтын бүтцийг ямар түвшинд бүрдүүлсэн бэ?

Хөндлөнгийн аудит - 75

Компаниуд санхүүгийн тайлангаа хөндлөнгийн аудитаар ямар түвшинд шалгуулдаг вэ?

Бие даасан баталгаажуулалт - 0

Компаниуд авлигын эсрэг хөтөлбөрийн бүтэц, хэрэгжилт болон үр ашгийн байдалд сайн дурын, хөндлөнгийн баталгаажуулалтыг ямар түвшинд хийлгэдэг вэ?

9 International Financial Reporting Standards буюу Олон улсын санхүүгийн тайланд тавигдах стандарт

ИЛ ТОД, НЭЭЛТТЭЙ БАЙДАЛ - 25

Судалгаанд хамрагдсан 100 компанийн 80 нь албан ёсны цахим хуудастай байв. Мөн эдгээрээс зөвхөн 19 компани авлигын эсрэг хууль тогтоомжийг дагаж мөрдөхөө илэрхийлжээ. Ердөө 9 компани санал гомдлын тусгай сувагтай болохоо мэдээлжээ. Нэг ч компани улс төрийн хандив, эсхүл түүнтэй адилтгах мэдээллийг ил тод мэдээлсэнгүй, мөн өөрийн эцсийн эзэн/өмчлөгчийнхөө талаар мэдээлээгүй байна. 22 компани хувьцаа эзэмшигчдийнхээ талаар мэдээлжээ. Түүнчлэн 22 компани ашиг орлого, зардлын талаарх мэдээлэл өгчээ. Лобби хийж буй үйл ажиллагааны талаар нэг ч компани ил тод мэдээлэл байршуулаагүй байна. Тухайлбал,

Авлигын эсрэг хөтөлбөрийн нээлттэй байдал - 25

Компаниуд авлигын эсрэг хөтөлбөрөө ямар түвшинд ил тод, нээлттэй тайлагнадаг вэ?

Байгууллагын бүтцийн нээлттэй байдал - 25

Компаниуд бүтэц зохион байгуулалтаа ямар түвшинд ил тод байлгадаг вэ?

Улс тус бүрийн үйл ажиллагааны нээлттэй байдал - 25

Компаниуд үйл ажиллагаагаа явуулж буй улс орны талаарх мэдээллийг хэр ил тод тайлагнадаг вэ?

Нэмэлт асуудлууд - 25

Компаниуд дотоод, гадаадын хандив, ивээн тэтгэсэн, лоббидсон үйл ажиллагаагаа хэр ил тод тайлагнадаг вэ? (тухайлбал, компанийн болон нийгмийн хариуцлагын тайлан)

ТАЛУУДЫН ОРОЛЦОО - 50

Бизнесийн байгууллагаас уриалсан авлигын эсрэг санал санаачилга тун ховор гардаг. Засгийн газраас авлигын эсрэг хэрэгжүүлж буй арга хэмжээ үр дүн багатай байгаа талаар мэдээлэхээс бусад тохиолдолд компаниуд өөрсдийн санаачилгаа илэрхийлэх сонирхолгүй байдаг. Идэвхтэй, нөлөө бүхий холбоодын тоо хангалтгүй байна. Тухайлбал,

Талуудын харилцаа - 75

Сайн компанийн засаглалыг хангахад компани өөрсдийн оролцогч талуудаа (хувьцаа эзэмшигч г.м) ямар түвшинд хамруулдаг вэ?

Авлигын эсрэг хувийн хэвшлийн санаачилга - 25

Авлигыг бууруулах олон талт санаачилгад компаниуд ямар түвшинд хамрагддаг вэ?

Бизнесийн холбоод - 75

Бизнесийн холбоод компаниудыг авлигын эсрэг тэмцэхэд ямар түвшинд дэмжлэг үзүүлдэг вэ?

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ - 25

ТУЗ-ийн бүх суурь үүргийг хуулиар зохицуулаагүй байна. Компаниуд ТУЗ, ТУЗ-ийн хороодын талаар, гишүүд болон удирдлагын ашиг сонирхлын зөрчилтэй гүйлгээ, үйл ажиллагааны талаар аливаа мэдээллийг ил болгодоггүй. ТУЗ-ийн үйл ажиллагаанд үнэлгээ хийсэн талаар огт мэдээлэл байхгүй. Тухайлбал,

Хяналт – 0

Компанийн ТУЗ авлигатай тэмцэх хөтөлбөрийг ямар түвшинд хариуцдаг вэ?

Удирдлагын нэмэлт цалин, урашлуулал - 25

ТУЗ-ийн гишүүн, компанийн дээд удирдлагын урамшууллын системийг ямар түвшинд стандартын дагуу олгодог вэ?

Ашиг сонирхлын зөрчил - 50

ТУЗ-ийн ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх хамгаалалт ямар түвшинд байна вэ?

0	Огт үгүй
25	Хязгаарлагдмал хэмжээнд
50	Тодорхой хэмжээнд
75	Нилээдгүй их
100	Бүрэн хэмжээнд

БИЗНЕСТ ҮЗҮҮЛЭХ АВЛИГЫН ХОР УРШИГ

Компанийн эрхэлж байгаа бизнесийн үйл ажиллагаанд авлигын үзүүлэх хор уршгийн талаар хүн бүр өөрсдийн туршлага, үзэл бодлын байр сууринаас тайлбарлах нь ойлгомжтой. Тэгвэл azcentral цахим хуудсан дээр Венди Робинсоны бичсэн нийтлэлд бизнесийн ёс зүй зөрчигдөж, авлига гарсан тохиолдолд тухайн бизнест ямар хор нөлөөтэй болохыг дурджээ.

Авлига нь бизнесийн үйл ажиллагаанд тулгарах хамгийн гол “дайсан”-ы нэг бөгөөд компанийн үйл ажиллагааг зогсооход хүргэх эрсдэлийг

дагуулдаг. Авлигын гэмт хэргийг тухайн компанид ажиллаж байгаа хэн нэгэн хувь этгээд, эсхүл үгсэн тохирсон бүлэг этгээдүүд үйлддэг. Бизнесийн хүрээнд үйлдэгддэг авлигын гэмт хэрэг нь төсвийг зориулалтын бусаар зарцуулах, хээл хахууль өгөх, авах, компанийн албан тушаалтан албан тушаалын байдлаа урвуулан ашиглах, санхүүгийн асуудалтай холбоотой зөрчил гаргах зэрэг олон хэлбэрээр илэрч болно. Гэвч авлигын үзүүлэх нөлөө нь тухайн компанийн бизнесийн нэр хүндэд сөргөөр нөлөөлж, олох байсан ашгийг эрсдэлд оруулдаг.

САНХҮҮГИЙН АЛДАГДАЛ

Авлигын улмаас тухайн аж ахуйн нэгж нь хөрөнгө шамшигдуулах, хээл хахууль өгөх зэрэг үйлдлийн улмаас хөрөнгө санхүүгийн алдагдал хүлээдэг. Бизнесийн үйл ажиллагаанд ашиглагдах байсан эх үүсвэр үр ашиггүй зүйлд зарцуулагддаг. Ийм нөхцөл байдал хэвийн үзэгдэл болсноор тухайн компанид итгэл алдарсан хэрэглэгчид өрсөлдөгч компанийн бараа, үйлчилгээг сонгоход хүрч, гарах алдагдлыг улам нэмэгдүүлдэг.

Түүнчлэн компанийн хэмжээнд гарч

байгаа авлигын улмаас үүссэн зардлыг нөхөх зорилгоор тухайн аж ахуйн нэгжийн үйлдэрлэж байгаа бараа, үзүүлж байгаа үйлчилгээний үнэ үндэслэлгүйгээр өсөх тохиолдол гарна. Энэ байдлыг овжноор ажигласан өрсөлдөгчид нь тухайн компанийн зах зээлд эзлэх байр суурийг ганхуулдаг. Түүнчлэн авлигын гэмт хэрэгт холбогдсон компани нь хэрэглэгч, түнш, олон нийтийн итгэлийг олж авах, авлигын гэмт хэргийн улмаас гарсан эрүүгийн шүүн таслах ажиллагааны зардал, хуулийн дагуу ял шийтгэлд заасан зардлыг барагдуулдаг.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ, ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫН ИТГЭЛИЙГ АЛДАХ

Тухайн компанид авлигын гэмт хэрэг гарсан мэдээллийн улмаас хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагчдын итгэл буурна. Авлига, хээл хахуулийн гэмт хэрэг үйлдэгдснээс бизнес эрхлэгчид борлуулалт буурах, хязгаарлагдмал эх үүсвэрийг үр

ашиггүй ашиглах гэх мэт эрсдлийг хүлээнэ. Цаашилбал, шинийг санаачлагчид, хөрөнгө оруулагчид дампуурахаас сэргийлж, тухайн компанитай хамтран ажиллахаас зайлсхийдэг.

БИЗНЕСИЙН НЭР ХҮНДЭД СӨРГӨӨР НӨЛӨӨЛӨХ

Компанийн дотор гарсан авлигын гэмт хэрэг тухайн бизнесийн байгууллагын нэр хүндэд сөргөөр нөлөөлдөг. Иргэд тухайн компанийн талаар сөрөг төсөөлөлтэй болсноор тухайн аж ахуйн нэгжийн үйлдэрлэж байгаа бараа, үзүүлж буй үйлчилгээнд итгэх итгэл нь

алдардаг. Улмаар хэрэглэгчээ төдийгүй нэр хүнд бүхий түншүүдээ алдахад хүргэж болзошгүй юм. Бизнесийн нэр хүнд хэрэглэгчийн итгэлийг олж авахад эргээд нэлээд цаг хугацаа шаардана.

БИЗНЕСЭЭС ОЛОХ ҮР АШГИЙГ БАГАСГАХ

Авлига нь хязгаарлагдмал эх үүсвэрийг үр ашиггүй зүйлд зарцуулахад хүргэдэг тул бизнесийн байгууллагын ашигт ажиллагаанд эрсдэл учруулдаг. Тухайн компанийн хэрэгжүүлж байгаа төслийн ажилд авлига нөлөөлснөөр үр дүн нь буурна. Түүнчлэн авлигын гэмт хэргийн талаар

мэдэж байгаа ажилтнуудын ажлын идэвх сулардаг бол хүний нөөцийн томилгоотой холбоотой авлигын хэрэг, зөрчлийн улмаас үр чадвар муутай мэргэжилтнийг тухайн компани хөлслөн авахад хүрдэг.

КОМПАНИА АВЛИГААГҮЙ БАЙЛГАХ, АВЛИГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ

6 АРГА ЗАМ



НҮБ-ын дэргэд үйл ажиллагаагаа явуулдаг Глобал Компакт байгууллага нь хувийн хэвшил, компаниудын үйл ажиллагаандаа мөрдлөг болгодог стратеги, бодлого төлөвлөлтийн баримт бичгийг хүний эрх, хөдөлмөр эрхлэлт, байгаль орчин, авлигатай тэмцэх нийтлэг журамд нийцүүлэх, түүнчлэн нийгмийн өмнө тавигдсан зорилтод хүргэх үйлдэл хийхийг тэднээс уриалахад чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг. Тус байгууллагын www.unglobalcompact.org цахим хуудаснаас компанийн үйл ажиллагаанд баримталбал зохих олон санааг олж үзэж болох бөгөөд Глобал Компакт байгууллагын ахлах менежер, хатагтай Неха Дасын бэлтгэсэн “Өөрийн компаниас авлигыг арилгах 6 алхам” хэмээх нийтлэлийг Танд сонирхуулья.

Авлига нь нийгэмд болон компанид муугаар нөлөөлж, санхүү, үйл ажиллагаа, нэр хүндэд хүчтэй эрсдэл учруулдаг. Өнөө үед компаниуд авлигын эсрэг бодлого арга хэмжээг чухалчлан авч үзэж, стратеги болон үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх болов.

Өөрийн компанид хариуцлагатай, ил тод байдлыг хөхиүлэн дэмжих 6 арга замыг дор дурдаж байна. Үүнд:

1**АМЛАЛТ ӨГӨХ:**

Авлигатай тэмцэх үйл хэргийг компанийхаа соёл, үйл ажиллагааны салшгүй хэсэг болго. Компанийн ажилтнууд, хэрэглэгчид, нийлүүлэгчдэд танай компани авлига, хээл хахуулийг үл тэвчих бодлого хэрэгжүүлдэг гэдгийг харуулаарай.

2**ҮНЭЛЭХ:**

Тулгарч болох эрсдэлээ сайтар тооцож бэлгэ. Хууль тогтоомж, дүрэм журмыг сахин биелүүлснээр бизнесийн үйл ажиллагаагаа сайжруулах боломжтойг ойлгоорой.

3**ТОДОРХОЙЛОХ:**

Танай компанийн хувьд амжилт гэж юу болохыг тодорхойл. Бодлого, стратеги, зорилгоо тодорхойлж, эдгээрийн ач холбогдлыг ажилтнууддаа ойлгуулж, дэмжлэгийг нь аваарай.

4**ХЭРЭГЖҮҮЛЭХ:**

Компанийн болон түүний бэлтгэн нийлүүлэгчдийн үйл ажиллагаанд салшгүй хэрэгжих авлигын эсрэг бодлого, хөтөлбөрөө гаргаарай.

5**ХЭМЖИХ:**

Хэмжиж болох бүх зүйлийг хэрэгжүүлж болдог. Авлигын эсрэг бодлого, хөтөлбөрийнхөө хэрэгжилтэд мониторинг хийж, юуг хэрэгжүүлсэн, юуг хэрэгжүүлэх шаардлагатай байгааг үнэлээрэй.

6**МЭДЭЭЛЭХ:**

Хувьцаа эзэмшигчиддээ хэрэгжүүлж байгаа ажлынхаа явцыг таницуулж, хүрэх үр дүнгээ чанаржуулахыг хичээгээрэй.

ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА



БНСУ-ын Лотте корпораци 1948 оны 6 дугаар сарын 28-ны өдөр байгуулагдсан бөгөөд одоогийн байдлаар 90 гаруй төрлийн бизнесийн чиглэлээр 60.000 гаруй ажилтантай

үйл ажиллагаагаа явуулж байна. Лотте компанийн үйл ажиллагааны чиглэл нь чихэр, амттан, ус ундааны үйлдвэрлэл, зочид буудал, түргэн хоолны үйлчилгээ, жижиглэн худалдаа, санхүүгийн үйлчилгээ, үйлдвэрлэлийн зориулалттай химийн бодис үйлдвэрлэл, цахилгаан бараа, мэдээллийн технологи-


програм хангамж, барилга, хэвлэл, зугаа цэнгэл гэх мэт салбаруудыг хамардаг.

Тус корпораци нь БНХАУ, Тайланд, Малайз, Индонез, Вьетнам, Энэтхэг, АНУ, Нэгдсэн Вант Улс, ОХУ, Филиппин, Пакистан, Польш Улсад салбар үйлдвэрлэл, үйлчилгээний газруудаа ажиллуулж байна.

Олон улс оронд үйл ажиллагаа явуулдаг тус корпорацийн хувьд бизнесийн ёс зүйдээ ихээхэн анхаарал хандуулдаг бөгөөд тус компанийн удирдах түвшний менежерүүд бизнесийн нэр хүндээ сайн байлгахад бизнесийн ёс зүй чухал ач холбогдолтойг ухамсарлан ойлгосон байдаг.

Эх сурвалж: https://en.wikipedia.org/wiki/Lotte_Corporation

Тус компани нь ёс зүйн харилцаагаа “итгэлд суурилсан” гэж томъёолсон байх бөгөөд дараах байдлаар ангилан авч үзсэн байна. Үүнд:



Тус корпорацийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа салбар компаниуд үйл ажиллагаандаа ёс зүйн дүрэм мөрддөг. Тус корпорацийн охин компани болох “Лотте Дюти Фри” компанийн хувьд ёс зүйн дүрэм нь дараах үндсэн хэсгүүдээс бүрдэж байна. Тухайлбал:

Хэрэглэгчиддээ өгөх амлалт

Хэрэглэгчийг хүндэтгэх

Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн баталгаа

Хэрэглэгчийн итгэлийг хадгалах

Түншүүддээ өгөх амлалт

Шударга худалдаа, хамтын хөгжил

Ёс зүйгүй үйлээс ангид байх

Ажилтнууддаа өгөх амлалт

Хууль тогтоомжийг сахин мөрдөх

Хүлээсэн үүргээ найдвартайгаар биелүүлэх

Харилцан хүндэтгэх

Мэдээлэл, нууцлалыг удирдах

Нийгэмд өгөх амлалт

Компанийн үйл ажиллагаа зөв эрүүл байх

Нийгэмд хувь нэмэр оруулах

Байгаль орчинд ээлтэй удирдлага хэрэгжүүлэх

Хөдөлмөрийн аюулгүй байдал, үйлдвэрлэлийн ослоос урьдчилан сэргийлэх

Үүнээс гадна тус компани нь бэлэг болон бүтээгдэхүүний дээжтэй холбоотой тусгай журмыг батлан мөрдүүлж байна. Энэхүү журмын дагуу бэлэг хэмээх ойлголтод бэлэн мөнгө, чек, карт, бэлгийн сертификат, үзвэрийн тасалбар, ваучер, бараа болон бусад зүйлсийг хамааруулахаар заасан байна. Түүнчлэн компанийн ажилтнуудыг бизнесийн үйл ажиллагаатай холбоотойгоор бэлэг авах, энэ талаар хүсэхийг журмаар хориглож, бэлэг авсан тохиолдолд Бэлэг буцаан өгөх төв эсхүл Ёс зүйн асуудал хариуцсан нэгжид мэдээлэхийг үүрэг болгосон. Ийнхүү мэдээлсэн бэлгийг Ёс

зүйн асуудал хариуцсан нэгж бүртгэж, буцааж өгөх ажлыг зохион байгуулдаг. Тухайн бэлгийг буцаан өгөх боломжгүй тохиолдолд олон нийтийн байгууллага, эсхүл дотоод дуудлага худалдааны байгууллагад хандивладаг. Дуудлага худалдаанаас олсон ашгийг санхүүгийн тайланд бүртгэсний дараа төрийн байгууллагад хандивладаг аж.

Бүтээгдэхүүний дээж зөвхөн бизнесийн зориулалтаар ашиглагдах бөгөөд хэрэглэсний дараа үлдэгдлийг нэгж, компанид буцаан олгох үүргийг журмаар зохицуулсан.

Тус компанийн зүгээс ёс зүйтэй бизнесийн харилцааг хөгжүүлэхийн тулд дараах үйл ажиллагаа, компани ажлыг явуулдаг байна. Үүнд:



Эх сурвалж: <https://en.lottedfs.com/about/lottedfs>


МОНГОЛ УЛСЫН ХУВИЙН ХЭВШИЛ ДЭХ АВЛИГЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Авлигын нөхцөл байдлын талаарх олон улсын түвшний судалгаануудаас гадна зөвхөн Монгол Улсын авлигын орчин, түүний дотор хувийн хэвшлийнхний дунд авлигын нөхцөл байдал ямар байгааг үнэлдэг судалгааг төрийн бус байгууллагууд уламжлал болгон хийсээр ирсэн билээ. Эдгээрийн нэг нь “Бизнес эрхлэлтийн орчин дахь авлигын нөхцөл байдлын судалгаа” юм.

Азийн сангаас эрхлэн гаргадаг уг судалгааны 2018 оны тайланд компанийн дотоод дахь шударга байдал, авлигатай тэмцэх хүсэл эрмэлзлэл, энэ чиглэлээр аж ахуйн нэгжүүдийн хэрэгжүүлж байгаа ажлын талаар үнэлгээ хийсэн байна.


Энэхүү судалгаагаар “Танай компани авлигатай тэмцэх чиглэлээр ямар нэгэн алхам хийсэн үү?” гэсэн асуултад 2018 оны 9 дүгээр сарын байдлаар “тийм” гэж хариулсан

бизнес эрхлэгчдийн тоо 17.3 хувь байсан. Энэхүү асуултад 2017 оны мөн үеийн байдлаар хувийн хэвшлийнхний 15.2 хувь нь “тийм” гэж хариулж байсантай харьцуулахад бага зэрэг өссөн байна. Түүнчлэн энэхүү асуултад “тийм” гэж хариулсан хариулт 2012 оноос хойш тасралтгүй нэмэгдэж байгаа нь бизнесийн салбарынхан авлигын хор хөнөөлийг ойлгон, ухамсарлаж байгааг илтгэж байна.




	2012/12	2013/05	2013/10	2014/04	2014/09	2015/09	2016/09	2017/09	2018/09
Мэдээлэл байхгүй	16.7%	13.9%	13.0%	13.3%	15.5%	13.3%	13.3%	11.8%	17.0%
Үгүй	71.5%	72.1%	74.5%	72.7%	71.5%	75.8%	72.4%	73.0%	65.8%
Тийм	11.8%	13.9%	12.4%	13.9%	13.0%	10.9%	14.2%	15.2%	17.3%

“Та авлигын талаар мэдээлэл өгч байсан уу?” гэх асуултад “тийм” гэж хариулсан хувийн хэвшлийнхэн 2018 оны 9 дүгээр сарын байдлаар 5.2 хувь байгааг хангалтгүй гэж үзэж болохоор байна. Энэхүү тоо нь 2012 оноос хойш хамгийн бага хэмжээндээ хүрсэн нь бизнес эрхлэгчид авлигын эсрэг хамгийн хүчтэй тэмцэл гэж үзэж болох түүнийг холбогдох байгууллагад мэдээлэх үүргээ хангалтгүй биелүүлж байгааг харуулж байна.



Та авлигын талаар мэдээлэл өгч байсан уу?



	2012/12	2013/05	2013/10	2014/04	2014/09	2015/09	2016/09	2017/09	2018/09
■ Мэдээлэл байхгүй	9.1%	10.6%	7.6%	3.6%	4.5%	4.2%	3.6%	3.3%	6.1%
■ Үгүй	81.8%	81.5%	83.6%	89.1%	86.7%	87.3%	87.3%	90.6%	88.8%
■ Тийм	9.1%	7.9%	8.8%	7.3%	8.8%	8.5%	9.1%	6.1%	5.2%

Тэгвэл авлигын талаар мэдээлсэн тохиолдолд цаашид гарах үр дүнгийн талаар хувийн хэвшлийнхэн дараах төсөөлөлтэй байна.


Хэрэв тийм бол, үр дүнд хүрсэн эсэх



	Мэдээлэл байхгүй/Хариулт алга	Зарим тохиолдолд Тийм/Үгүй	Үгүй	Тийм
2014/09	17.2%	31.0%	37.9%	13.8%
2015/09	10.7%	14.3%	60.7%	14.3%
2016/09	10.0%	26.7%	43.3%	20.0%
2017/09	5.0%	30.0%	40.0%	25.0%
2018/09	11.8%	17.6%	52.9%	17.6%


Хувийн хэвшлийн байгууллага авлигатай тэмцэх дотоод журмыг бизнесийн ёс зүйн дүрэмтэйгээ уялдуулан батлан мөрдүүлэх нь авлигаас урьдчилан сэргийлэх, түүнийг таслан зогсооход чухал хувь нэмрийг оруулдаг. Тэгвэл авлигын эсрэг дотоод журам хэрэгжүүлж байгаа аж ахуйн нэгж нийт судалгаанд оролцогчдын 20 хувийг эзэлж байгаа бөгөөд энэ нь 2012 оноос хойш хамгийн их хэмжээнд хүрсэн байна. Гэвч хувийн аж ахуйн нэгжүүд ийм дотоод журмыг энэхүү гарын авлагад дурдсан Лотте болон энэ чиглэлээр амжилттай үйл ажиллагаа явуулж байгаа гадаад, дотоодын компаниудын жишгээр боловсруулж мөрдүүлэх шаардлагатай байна.

Авлигатай тэмцэх дотоод журамтай эсэх





	2012/12	2013/05	2013/10	2014/04	2014/09	2015/09	2016/09	2017/09	2018/09
■ Мэдээлэл байхгүй	15.5%	15.2%	7.0%	6.1%	7.6%	7.0%	7.0%	4.8%	6.7%
■ Үгүй	74.8%	70.6%	73.6%	77.0%	78.5%	77.6%	78.2%	81.2%	73.3%
■ Тийм	9.7%	14.2%	19.4%	17.0%	13.9%	15.5%	14.8%	13.9%	20.0%

“Бизнесийн орчинг авлигагүй болгохын тулд танай байгууллага ямар арга замыг сонгох вэ?” гэсэн асуултад 2018 оны 9 дүгээр сарын байдлаар “аль ч тохиолдолд шударга зарчмаар ажиллах” гэж судалгаанд оролцогчдын дийлэнх хэсэг буюу 45.8 хувь нь хариулсан байна. Тэгвэл “Авлигатай тэмцэх газарт мэдэгдэх” гэж судалгаанд оролцогчдын 6.4 хувь нь хариулжээ. Бизнесийн байгууллага шударга зарчмаар ажиллах нь авлигын эсрэг тэмцэхэд чухал ач холбогдолтой боловч авлигыг таслан зогсоохын тулд холбогдох төрийн байгууллагад мэдээлэх, шүгэл үлээх явдал ач холбогдолтой болохыг хувийн хэвшлийнхэн ойлгож хэрэгжүүлэх хэрэгтэй юм.



Бизнес орчинг авлигагүй болгохын тулд танай байгууллага ямар арга замыг сонгох вэ?



Хэдийгээр бизнесийн орчинд авлигын үзүүлэх хор уршгийг хувийн хэвшлийнхэн ойлгон ухамсарлаж байгаа боловч түүнийг холбогдох байгууллагад мэдээлэх, компанийнхаа ажилтнуудыг авлигаас урьдчилан сэргийлэх дүрэм, журмыг боловсруулан мөрдүүлэх талаар хүчин чармайлт хангалтгүй гаргаж байна. Авлигыг мэдээлэхдээ нэрээ нууцлах, шүгэл үлээх зэрэг далд хэлбэрүүдийг ашиглах нь чухал үр нөлөөтэй байдгийг бизнес эрхлэгчид харгалзан үзэх хэрэгтэй юм. Цаашид компанийхаа дотоодод шүгэл үлээгчдийг хамгаалах, тэднийг урамшуулах тогтолцоог бий болгох шаардлага байгааг Та бодолцон үзэх хэрэгтэй.

Эх сурвалж:


https://asiafoundation.org/wp-content/uploads/2019/03/2018-Study-of-Private-Sector-Perceptions-of-Corruption_STOPP_Eng.pdf

ШУДАРГА ЁС, ХӨГЖИЛ ДЭВШИЛД: ХУВИЙН ХЭВШЛИЙН ОРОЛЦОО

Монгол Улсын авлигын эсрэг хууль тогтоомжоор авлигатай тэмцэх ажилд үүрэг хүлээгээгүй нэг ч байгууллага, албан тушаалтан, иргэн үгүй бөгөөд Авлигатай тэмцэх газраас төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшил, хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран ажиллаж, авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг олон арга хэлбэрээр зохион байгуулдаг.

УИХ-ын 2009 оны 64 дүгээр тогтоолоор баталсан “Төр, хувийн хэвшлийн түншлэлийн талаар төрөөс баримтлах бодлого”-д “Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилгод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогод тусгагдсан хувийн хэвшил тэргүүлсэн эдийн засгийн эрчимтэй өсөлтийг хангах, бүх талын түншлэлийг хөхиүлэн дэмжих замаар Монгол Улсын эдийн засгийг тогтвортой хөгжүүлэхэд түлхэц болоход энэхүү бодлогын зорилго оршино.” гэж тодорхойлсон бөгөөд энэ нь төрийн байгууллагаас бодлого шийдвэр гаргахад хувийн хэвшлийнхний саналыг тусгах, эрх ашгийг нь хамгаалах, төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг өргөжүүлэх, төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшилд, тухайн салбарын мэргэжлийн холбоодод шилжүүлэх зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэхэд тодорхой дэмжлэг болж байна.

Үндэсний хөгжлийн цогц бодлогын үргэлжлэл болгон “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-ыг 2016 онд батлан гаргасан бөгөөд Монгол Улс цаашид тогтвортой засаглалыг



хангах үзэл баримтлалыг баримтлан ажиллах чиглэлээр “Төрийн бүх шатны байгууллагын удирдлагын манлайллыг дээшлүүлэх, бүх нийтийн оролцоо, төр, хувийн хэвшлийн түншлэлийг хангасан ил тод, хариуцлагатай засаглалыг үндэсний болон орон нутгийн түвшинд бүрдүүлэх зорилтуудыг хэрэгжүүлж байна.

“Бизнес эрхлэгчид хээл хахууль, давуу байдал бий болгох зэрэг авлигын бүх хэлбэрийн эсрэг ажиллах ёстой” гэж НҮБ-ын Даян дэлхийн гэрээний 10 дахь зарчимд тунхагласан байдаг. Монгол Улс 2005 онд Авлигын эсрэг НҮБ-ын Конвенцид нэгдэн орсон бөгөөд Конвенцид заасан хувийн хэвшлийг авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр авч болох арга хэмжээг хэрэгжүүлж эхэлсэн. Монгол Улсын Авлигын эсрэг хуульд заасны дагуу хувийн хэвшлийн байгууллагууд авлигаас урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд үйл ажиллагааныхаа ёс зүйн зарчмуудыг тогтоож, дагаж мөрдөх үүргийг хүлээдэг. Бизнесийн бүх салбарын үйл ажиллагааны зарчим нь ёс зүйд үндэслэсэн, шударгаар өрсөлдөх боломжийг бүрдүүлсэн байх учиртай. УИХ-ын 2016 оны 81 дүгээр тогтоолоор батлагдсан Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрт “Хувийн хэвшил дэх авлигын эрсдлийг бууруулах, шударга өрсөлдөөнийг хангах” зорилтыг дэвшүүлэн хэрэгжүүлж байна.

Дээр дурдсанчлан төрөөс баталсан бодлого, хөтөлбөрүүдэд бизнесийн байгууллагууд ёс зүйг чандлан сахих, хууль дээдлэх, авлигатай тэмцэх, ардчилсан иргэний нийгмийг хөгжүүлэхэд оролцох талаар хангалттай тусгажээ. Харин тэдгээрийг амжилттай хэрэгжүүлэхийг олон нийт хүлээж байгаа нь гарцаагүй.

Авлигаас ангид байж, нийтийн ашиг сонирхлыг дээдлэн, ес зүйтэй, шударгаар өрсөлдөж, түншлэлээ бэхжүүлэн, бизнесээ өргөтгөж, улс орноо хөгжүүлэхэд хувийн хэвшлийнхэн манлайлан оролцож чадна гэдэгт эргэлзэхгүй байна. Танд амжилт хүсье!

ХАВСРАЛТ

КОМПАНИЙХАА АВЛИГЫН ЭРСДЭЛИЙГ ТОДОРХОЙЛЦГООЁ

Танай компани тухайн асуудлыг хэрхэн хэрэгжүүлж байгаа хариулт тус бүрийг 1-10 оноогоор үнэлнэ үү (0 хамгийн бага, 10 хамгийн их).

№	Асуулт	Үнэлгээ
1	Бизнесийн байгууллагын гишүүн бүр ижил итгэл үнэмшил, үнэт зүйл, үйл ажиллагааг эрхэмлэж байна уу?	
2	Хэрэв тийм бол эдгээр итгэл үнэмшил, үнэт зүйлс, үйл ажиллагаа нь доорх зүйлсийн тусламжтай хэрэгждэг үү? а. Тусгайлсан тодорхойлолт ба мэдээлэн сурталчлах ажиллагаа б. Журам, удирдамж ба түүний хэрэгжилт с. Мониторинг, урамшуулал, хариуцлага тооцох ажиллагаа	
3	Байгууллагын шинэ гишүүд сургалт, мэдээллийн цагт сууж, танай компанийн үнэт зүйлийн талаар мэдлэг ойлголттой болж байна уу?	
4	Байгууллагын шинэ гишүүдийг энэхүү үнэт зүйлсийг ойлгож ухамсарлаж байгаа эсэхийг үндэслэж, ажилд шалгаруулж авдаг уу?	

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

5	Компанийн удирдлага болон ажилтнууд ёс зүйн соёл бол a. сайн бизнес юм b. итгэл, нэр хүндийг нэмэгдүүлдэг c. ашиг, нийгмийн хариуцлагын гол шалгуур d. хувь хүний хариуцлагыг хөнгөвчилдөг e. эрсдлийн удирдлагыг хэрэгжүүлэх нөхцөл болдог f. туслах урам зоригийг өдөөж өгдөг гэдгийг ойлгож, хүлээн зөвшөөрдөг үү?	
6	Компанийн удирдлага нь хууль тогтоомж, ёс зүйг мөрдөж ажиллахыг нийт ажилтнуудад ухуулан таниулж, ажилтнуудтай харилцах өдөр тутмын харилцаандаа сануулдаг уу?	
7	Компанийн удирдлага нь байгууллагын үнэт зүйлийг загваржуулж, өдөр тутмын шийдвэр гаргах ажиллагаандаа ёс зүй, хууль тогтоомжийг сахин мөрдөх зан үйлийг үлгэрлэж, ажилтанд хариуцлага тооцохдоо баримталж байна уу?	
8	Эх үүсвэрийг хуваарилах шийдвэрийг шударгаар гаргаж байна уу?	
9	Байгууллагын гишүүд эх үүсвэрийг шударгаар хуваарилна гэдэгт итгэлтэй байна уу?	
10	Байгууллагын гишүүд удирдах түвшний менежерүүд ёс зүйн хүрээнд ажлаа явуулж, үүрэг чиглэл өгч байгаа гэдэгт итгэлтэй байна уу?	
11	Хүмүүсийг хэлсэн, хийснийх нь төлөө хариуцлага хүлээлгэх журам, тогтолцоо бүрдсэн үү?	
12	Холбогдох хүн бүр асуудлыг хэлэлцэхэд оролцож, эсрэг саналаа илэрхийлэх боломжтой байна уу?	
13	Танай байгууллага шүгэл үлээгч (мэдээлэгч)-ийн нэрийг нууцлах, хамгаалах журамтай юу?	

Тайлбар: Нийт оноо 650-иас доош бол хангалтгүй, 650-1300 бол хангалттай гэж үзнэ.

Та энэхүү судалгааг өөрийн байгууллагын ажилтнуудыг оролцуулан зохион байгуулж, үр дүнгийн талаар Авлигатай тэмцэх газрын contact@iaac.mn цахим хаягаар ирүүлнэ үү. Таны ирүүлсэн мэдээллийг бид авлигаас урьдчилан сэргийлэх ажилдаа ашиглах болно.

Эх сурвалж: <https://www.i-c-solutions.net/wp-content/uploads/2017/01/Ethics-Culture-Assessment-Checklist.pdf>



АВЛИГАТАЙ
ТЭМЦЭХ ГАЗАР

ШУДАРГА ЁС, ХӨГЖИЛ ДЭВШИЛД



ГОМДОЛ, МЭДЭЭЛЭЛ ХҮЛЭЭН АВАХ УТАС
/Төлбөр 0₮/



UIH.MN
СУДАЛГААНЫ САН



АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР
ШУДАРГА ЁС, ХӨГЖИЛ ДЭВШИЛД



Гомдол, мэдээлэл хүлээн авах утас
/Төлбөр 0₮/

Гомдол, мэдээллээ цахимаар өгөх бол
www.iaas.mn хаягаар хандана уу.



UIH.MN
ТГ ААНЫ САН